

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр

1. Монголросцветмет” ТӨҮГ нь Байгаль орчны аудит хийлгэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшилд буй тусгай зөвшөөрөлтэй талбайнуудыг ашиглах төсөлд Байгаль орчны аудит хийх үйлчилгээ болно. Уг үйлчилгээнд дараах тусгай зөвшөөрөлтэй талбайнууд хамаарна. Үүнд:
 - Багц 1: MV-000174 тусгай зөвшөөрөлтэй Бор-Өндөрийн далд уурхай ба баяжуулах үйлдвэр төсөл /Хэнтий, Бор-Өндөр/
 - Багц 2: MV-000173 тусгай зөвшөөрөлтэй Адагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл, /Хэнтий, Дархан/
 - Багц 3: MV-004306 тусгай зөвшөөрөлтэй Төв үнэгтийн хайлуур жоншны ордыг ашиглах төсөл, /Дундговь, Баянжаргалан/
 - Багц 4: MV-004487 тусгай зөвшөөрөлтэй Зүүн үнэгтийн хайлуур жоншны ордыг ашиглах төсөл, /Дундговь, Баянжаргалан/
 - Багц 5: MV-016657 тусгай зөвшөөрөлтэй Баргилтын төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төсөл, /Хэнтий, Дархан/
 - Багц 6: MV-000159 тусгай зөвшөөрөлтэй Хамар-Ус хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл /Дорноговь, Иххэт/
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
 - Тусгай зөвшөөрөл
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2020 оны 05 дугаар сарын 27–ны өдрийн 09 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2020 оны 05 дугаар сарын 28– ний өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 409 тоот,

И-мейл: mailbox@monros.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-142